



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/17

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 01 дүгээр албан бичиг, тус сумын сургуулийн захирлын 2018 оны 134 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сумын хүүхдийн цэцэрлэгт улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 38,053,100 (Гучин найман сая тавин гурван мянга нэг зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, тус сумын ерөнхий боловсролын сургуульд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 74,672,000 (Далан дөрвөн сая зургаан зуун далан хоёр мянган) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар, 31,113,700 (Гучин нэгэн сая нэг зуун арван гурван мянга долоон зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий үдийн цай нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог гуравдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (А.Амаржаргал), ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Мягмармаа) нарт тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Л.ГАНБОЛД

01110013

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 15-ны өдрийн А/17 дугаар
захирамжийн 01 дүгээр хавсралт



ТӨМӨРБУЛАГ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХООЛ,
ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-38,053,100 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: А.Үүрийнцолмон-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

Ц.Ганболд-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

Б.Цэцгээ-Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн

Нарийн бичгийн дарга: Ч.Лхагвамядаг-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 15-ны өдрийн А/17 дугаар
захирамжийн 02 дугаар хавсралт



**ТӨМӨРБУЛАГ СУМЫН ХҮҮХДИЙН ЕБС-д ХООЛ,
ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**
(Төсөвт өртөг-74,672,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: А.Үүрийнцолмон-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

Ц.Ганболд-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

Б.Цэцгээ-Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн

Нарийн бичгийн дарга: Ч.Лхагвамядаг-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 15 -ны өдрийн А/17 дугаар
захирамжийн 03 дугаар хавсралт



**ТӨМӨРБУЛАГ СУМЫН ХҮҮХДИЙН ЕБС-д ҮДИЙН ЦАЙ
НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**
(Төсөвт өртөг-31,113,700 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: А.Үүрийнцолмон-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

Ц.Ганболд-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

Б.Цэцгээ-Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн

Нарийн бичгийн дарга: Ч.Лхагвамядаг-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн мэргэжилтэн